



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аж ахуйн нэгжүүдийн хандиваар төвлөрүүлэхээр тооцсон 2,400.0 сая төгрөгийн орлого нь гэрээ хэлцэл, бусад нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа нь орлого төвлөрөхгүй байх, хий орлого, зарлага төлөвлөх эрсдэлийг үүсгэж байна.

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ДҮГНЭЛТ ӨГӨХ АУДИТ**

АУДИТЫН КОД: СЭА-2022/14-17-ШТА-ТД



Сүхбаатар сум
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа
Утас: 70363040, Цахим хаяг:
Enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх
Утас: 70363036, Цахим хаяг:
Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Отгонбаяр
Утас: 70362442, Цахим хаяг:
Otgonbayarts@audit.gov.com

Аудитор Д.Чулуунцэцэг
Цахим хаяг: Chuluuntsetseg.d@audit.gov.mn



**Аудитыг
гүйцэтгэсэн:**

Сэлэнгэ аймаг
дахь Төрийн
аудитын газар

Дарга,
тэргүүлэх
аудитор:
Ч.Энхтуяа

Аудитын
менежер:
Б.Батмөнх

Ахлах
аудитор:
Ц.Отгонбаяр
Б.Баасансүрэн
Аудитор:
Д.Чулуунцэцэг
О.Анхбаяр
Ж.Цогт
З.Золбоо

**Хаяг: Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум,
аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд**

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хавсралтын товъёг.....	3
Аудитын талаарх ерөнхий мэдээлэл.....	4

Үндсэн мэдээлэл

НЭГ: Татварын өрийг барагдуулж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцоогүй байна.

- *Хандиваар төвлөрүүлэхээр тооцсон орлого нь аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээ хэлцэл, бусад нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа нь орлого төвлөрөхгүй байх, хий орлого төлөвлөх эрсдэлийг үүсгэж байна.*
- *Татварын өрийн тодорхой хэсгийг барагдуулснаар төвлөрүүлэх орлогыг огт төсөвлөөгүй байна.*

ХОЁР. Орон нутгийн төсвийн зарлагыг хууль тогтоомжид нийцүүлэн үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэйгээр төлөвлөөгүй байна.

- *Аймгийн ОНХС болон ОНХО-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөдөг зөрчил давтагдсаар байна.*
- *Тухайн байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой, хэт жижиглэсэн төсөл, арга хэмжээ болон улсын төсөвт байгууллагуудын зардлыг ОНХО-ын төсөвт тусгасан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.*



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ХО	Хөрөнгө оруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Хавсралтын товч

№	Тайлбар
Хавсралт 1	Зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр аймгийн ОНХО-ын хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 2	Зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр аймгийн ОНХО-ын хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт /Хандивын хөрөнгөөр/
Хавсралт 3	Зураг төсөв, тооцоо судалгаагүйгээр аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 4	Иргэдийн саналгүйгээр аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт
Хавсралт 5	Аймгийн ОНХО-аар 2023 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тухайн төсвийн байгууллагын урсгал зардалд тусгах боломжтой төсөл, арга хэмжээний жагсаалт

**Аудитын талаарх ерөнхий мэдээлэл****Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтыг үндэслэн Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Сэлэнгэ аймгийн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ-д хүргүүлэн, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Энэ зорилготой холбоотой дараах асуудлын хүрээнд аудитыг төлөвлөж гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг хууль, эрх зүйн актад нийцүүлэн, нөөц боломжийг бүрэн ашиглаж төсөвлөсөн үү?
- Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актад нийцүүлэн, арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн үү?

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817 : 2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 болон А/71 дүгээр тушаалуудаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, “Нийцлийн аудитын заавар, аргачлал” 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлалыг шалгуур болголоо.

**Аудитын
хамарсан хүрээ**

Аудитын явцад Сэлэнгэ аймгийн 2021, 2022 оны батлагдсан төсөв, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн төсөл, холбогдох танилцуулга мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа,



**Талуудын хүлээх
үүрэг, хариуцлага**

**Аудитын хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

мэдээлэлд үндэслэн нөхцөл байдлыг тодорхойлон дүн шинжилгээ хийлээ.

Аймгийн Засаг дарга нь Сэлэнгэ аймгийн 2023 оны төсвийг холбогдох шаардлагад нийцүүлэн боловсруулж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй.

Аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн аймгийн 2023 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, С.Баасансүрэн, аудитор Д.Чулуунцэцэг, О.Анхбаяр, Ж.Цогт, З.Золбоо нар 2022 оны 09 дүгээр сарын 19-өөс 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл

УИХ-аас аймгийн татварын орлогыг 18,040.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,597.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 3,278.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 16,630.7 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогыг 4,318.4 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр болон зарлагыг тус бүр 36,228.2 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга нь УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн орлого, зарлагыг нийт 11,379.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 47,607.8 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.



Бүлэг 1

Орон нутгийн төсвийн орлогыг хууль, эрх зүйн актад нийцүүлэн, нөөц боломжийг бүрэн ашиглаж төлөвлөсөн үү?

Татварын өрийг барагдуулж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх нөөц боломжийг тооцоогүй байна.

1.1 Орон нутгийн төсвийн орлогыг хууль, журмын дагуу үндэслэлтэй боловсруулж төсөвлөсөн үү?

Хандиваар төвлөрүүлэхээр тооцсон орлого нь аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээ хэлцэл, бусад нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа нь орлого төвлөрөхгүй байх, хий орлого төлөвлөх эрсдэлийг үүсгэж байна.

УИХ-аас аймгийн татварын орлогыг 18,040.0 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 2,597.0 сая төгрөгөөр, сумдаас аймагт төвлөрүүлэх орлогыг 3,278.9 сая төгрөгөөр, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 16,630.7 сая төгрөгөөр, улсад төвлөрүүлэх орлогыг 4,318.4 сая төгрөгөөр тооцон төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 36,228.2 сая төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

Аймгийн Засаг дарга нь УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн орлогыг нийт 11,379.6 сая төгрөгийг нэмэгдүүлэн 47,607.8 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна. Нэмэгдүүлэн төсөвлөсөн орлогыг нэр төрлөөр нь харуулбал:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 3,600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 19,600.0 сая төгрөгөөр,
- Сумдын төсвөөс төвлөрүүлэх орлогыг 3,024.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 6,303.5 сая төгрөгөөр төсөвлөсөн бол,
- Хандив тусламжийн орлогоос 3,100.0 сая төгрөг, мөнгөн хөрөнгийн урьд оны үлдэгдлээс 400.0 сая төгрөг, ОНХС-ийн өмнөх оны үлдэгдлээс 1,255.0 сая төгрөг төвлөрүүлэхээр гэх мэт.

Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2-т “Доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт дараах байдлаар төвлөрүүлнэ, 56.2.1: доод шатны төсвийн үндсэн тэнцлийн ашиг нь суурь зарлагаас бага болон тэнцүү тохиолдолд үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг 2020 оны төсвийн жилээс эхлэн тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлнэ.” гэж заасан байдаг.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1-д зааснаар ХХОАТ нь сумдын төсөвт төвлөрдөг болж, тухайн татвараас төвлөрүүлэх орлогын боломжийг



тооцон Ерөө, Мандал, Сүхбаатар, Хүдэр сумдаас нийт 6,303.5 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байна.

Сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон дээрх орлого нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан нөхцөл, боломж, хувь хэмжээг хангаж буй эсэхийг дахин тооцоолж үзэх нь зүйтэй юм.

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. 59.1.3: Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж хандив”, 60 дугаар зүйлийн 60.2.9-д “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив тусламж” гэж заасан байдаг.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс хандиваар төвлөрүүлэхээр тооцсон 2,400.0 сая төгрөгийн орлого болон өмнөх онуудад ОНХС-д хандиваар төвлөрсөн 700.0 сая төгрөг зэрэг нийт 3,100.0 сая төгрөгийг хандив тусламжийн орлогоор тооцож төсөвлөсөн байна.

2023 онд хандиваар төвлөрүүлэхээр төсөвлөсөн 2,400.0 сая төгрөгийг ямар аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлэх нь тодорхой бус бөгөөд энэ нь аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээ хэлцэл болон бусад дэмжих баримтаар нотлогдохгүй байгаа нь орлого төвлөрөхгүй байх, хий орлого төлөвлөх эрсдэлийг үүсгэж байна.

Иймээс хандив тусламжаар төвлөрүүлэх 2,400.0 сая төгрөгийг гэрээ хэлцэл, бусад дэмжих баримтаар баталгаажуулсны үндсэн дээр төлөвлөх, урьд оны хандив тусламжийн үлдэгдлийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээр тооцож төсөвлөх нь зүйтэй юм.

1.2 Орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх нөөц боломжийг бүрэн ашигласан уу?

Татварын өрийн тодорхой хэсгийг барагдуулснаар төвлөрүүлэх орлогыг огт төсөвлөөгүй байна.

Монгол Улсын жил бүрийн Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад “Татвар хураалт орлого бүрдүүлэлтийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлт”-ийн зорилтот түвшинг тооцохдоо өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалтыг 70 хувиар, тайлант хугацааны / төлөвлөж буй жилийн өмнөх жил / татварын тайлангийн ногдол өр барагдуулалтыг 80 хувиар тус тус тогтоож, төсвийн орлогыг төлөвлөсөн байдаг.

Гэтэл өмнөх онуудын болон 2022 оны татварын өрийг тодорхой хэмжээгээр барагдуулснаар төвлөрөх орлогыг 2023 онд огт төсөвлөж, тооцоогүй байгаа нь татварын өр барагдуулалтаар төвлөрсөн орлого нь тайлант оны татварын орлогын төлөвлөгөөний биелэлтээр тооцогдох эрсдэлийг үүсгэж, орлого төвлөрүүлэх нөөц боломжийг алдагдуулж байна.



Тухайлбал, Аймгийн 2022 оны эхний хагас жилийн татварын орлогын мэдээгээр нийт 6,571.9 сая төгрөгийн татварын өр тайлагнагдсан бөгөөд үүний дөнгөж 30 хувийг барагдуулахаар төлөвлөхөд төсвийн орлого **1,971.6 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх нөөц боломжтой байна. */Дэлгэрэнгүй тооцооллыг хавсралтаар харуулав*

Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-д “Нийслэл, орон нутгийн чанартай авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ”; 25.2.6-д “Авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр” гэж заасан боловч уг орлогыг огт тооцож, төлөвлөөгүй байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/15 тоот захирамжийн 4 дүгээр хавсралтаар “Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдээс авто зам ашигласны төлбөр авах журам”-ыг баталж, зөвхөн авто машины зам ашигласны төлбөрийн хэмжээг тогтоосон боловч авто замын зурвас газарт үйлчилгээ эрхэлсний төлбөрийг тогтоогоогүй байна.



Орон нутгийн төсвийн зарлагыг холбогдох хууль эрхийн актад нийцүүлэн, арвилан хэмнэлт, үр ашигтай байхаар төлөвлөсөн үү?

Орон нутгийн төсвийн зарлагыг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөөгүй байна.

2.1 Орон нутгийн төсвийн зарлагыг хууль эрхийн актад нийцүүлэн төлөвлөсөн үү?

Аймгийн ОНХС болон ОНХО-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөдөг зөрчил давтагдсаар байна.

УИХ-аас Сэлэнгэ аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн нийт зарлагыг 36,228.2 сая төгрөгөөр баталж ирүүлснийг 11,379.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 47,607.8 сая төгрөгөөр өргөн мэдүүлсэн байна. Нэмэгдүүлж төсөвлөсөн зарлагуудыг нэр төрлөөр нь харуулбал:

- Төсвийн урсгал зардлыг 4,777.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 12,705.8 сая төгрөгөөр,
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 5,316.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8,611.1 сая төгрөгөөр,
- Сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 30.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8,405.1 сая төгрөгөөр,
- ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 1,255.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 17,885.7 сая төгрөгөөр гэх мэт.

Засаг даргаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд төрийн үйлчилгээний албан



хаагчдын үндсэн цалинг 30.0-40.0 хувиар, төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 30.0 хувиар нэмэгдүүлсэн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг төрд ажилласан жилээр тооцож цалин, НДШ-ийн зардлыг 2,115.7 сая төгрөгөөр, Спортын байгууллагын тогтмол зардлыг 403.2 сая төгрөгөөр, Засаг даргын нөөц санг 927.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн болон ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлыг 1,000.0 сая төгрөгөөр, бусад зардлыг 331.3 сая төгрөгөөр төсөвлөсөн зэргээс шалтгаалан урсгал зардлыг нийт дүнгээр 4,777.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж өргөн мэдүүлсэн байна.

Байгалийн төлбөрийн тухай хууль болон Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “*Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам*”-ын дагуу байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний жагсаалтад 1,664.5 сая төгрөгийг 24 төсөл арга хэмжээг тусгасан байна.

Аймгийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлж буй 2023 оны төсвийн төсөлд зарим зардлыг Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль, эрхийн актыг зөрчиж төсөвлөсөн байна. Үүнд:

- Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төсөвлөөгүй,
- Аж ахуйн нэгжүүдийн хандивын орлогоор тооцсон 2,400,0 сая төгрөгийн эх үүсвэрийг ОНХС-ийн төсөл, арга хэмжээний бус ХО-ын төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхээр төсөвлөсөн,
- Зураг төсөө, үнэ өртгийн тооцоо судалгаа хийгдээгүй буюу төсөвлөлтийн шаардлага хангаагүй 2,048.1 сая төгрөгийн өртөг бүхий 18 төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр, аймгийн төсөвт төвлөрөх хандивын хөрөнгөөр 7 төсөл, арга хэмжээнд 2,135.0 сая төгрөг, ОНХС-ийн жагсаалтад 27 төсөл, арга хэмжээнд 4,485.0 сая төгрөг тусгаж, төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹ дэх заалтыг зөрчсөн байна./Дэлгэрэнгүйг Хавсралт 1, 2, 3-т харуулав /
- ОНХС-ийн төлөвлөгөөнд орон нутгийн иргэдийн саналыг аваагүй 3,316.3 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно, 60.3.6 : Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй... зардал, арга хэмжээ” гэсэн заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 4-т харуулав /
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж, иргэд, олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй, санал авч, эрэмбэлэх ажил хийгдээгүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл

¹ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



ажиллагааны журам"-ын 7.4², 7.5³ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

- Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, нээлттэй хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн, ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй байгаа нь дээрх журмын 7.6⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

2.2 Орон нутгийн төсвийн зарлагыг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төсөвлөсөн үү?

Тухайн байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой, хэт жижиглэсэн төсөл, арга хэмжээ болон улсын төсөвт байгууллагуудын зардлыг ОНХО-ын төсөвт тусгасан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.

Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах үйл ажиллагааг Монгол улсын тухайн жилийн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрхийн актууд, төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжид нийцүүлэн орон нутгийн төсвийн зардлыг үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй байхаар төсөвлөх ёстой.

Гэтэл аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн орон нутгийн төсвийн төсөлд батлагдсан орон тооны хязгаарыг нэмэгдүүлсэн, төсөл арга хэмжээг зардлын дэлгэрэнгүй тооцоо судалгаагүйгээр бөөн дүнгээр төлөвлөсөн зэрэг үр ашиг, арвилан хэмнэлтгүй дараах зардлууд төсөвлөгджээ. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12⁵ -д “ТЕЗ нь эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, ... зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.” гэж заасан атал аймгийн ЗДТГ-ын гэрээт ажилтны орон тоог хязгаараас 11-ээр нэмэгдүүлж 203.1 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал, СХАА-ны орон тоог 2-оор нэмэгдүүлж 39.5 сая төгрөгийн цалин, НДШ-ийн зардал төлөвлөсөн,
- Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 1,000.0 сая төгрөгийн зардлуудыг төсөл, арга хэмжээгээр салгаж, тооцоо судалгаа хийлгүйгээр эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, соёл урлагийн салбар гэх зэргээр бөөн дүнгээр төсөвлөсөн нь төсвийн хяналт сулрах, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.
- Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн нийт 352.4 сая төгрөгийг /Дэлгэрэнгүйг Хавсралт 5-т харуулав / тухайн төсвийн байгууллагын урсгал зардалд тусгах

² Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

³ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

⁴ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

⁵ 14.2.Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.



боломжтой урсгал засвар, техник тоног төхөөрөмж, тохижилтод зарцуулахаар буюу хэт жижиглэн төсөвт тусгуулахаар өргөн мэдүүлсэн нь хөрөнгө оруулалтын нийтэд хүртээх үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал, 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мэдээлэл зүйн кабинетын тоног төхөөрөмж / Сүхбаатар сум, 5-р сургууль /, 11.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж / Алтанбулаг сум /” гэх мэт.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар төсөв, санхүүгийн боломж харьцангуй сайтай улсын төсвийн байгууллагууд болох шүүх, цагдаа зэрэг хууль хүчний байгууллагуудын барилгын засварыг гүйцэтгэхээр төлөвлөж байгаа нь орон нутгийн төсвөөс санхүүжигч байгууллагууд, ард иргэдэд хүртэх үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал, Аймгийн Шүүхийн өргөтгөлийн барилгын засварт 38.1 сая төгрөг, аймгийн Цагдаагийн газрын барилгын гадна фасад засварт 350.0 сая төгрөг төсөвлөсөн байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн суурь орлого, зарлагыг нийт 11,379.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 47,607.8 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.
- Аж ахуйн нэгжүүдийн хандиваар төвлөрүүлэхээр тооцсон орлого нь гэрээ хэлцэл болон бусад дэмжих баримтаар баталгаажаагүй нь орлого төвлөрөхгүй байх, хий орлого төлөвлөх эрсдэлийг үүсгэж байна.
- Татварын өрийн тодорхой хэсгийг барагдуулснаар орлого төвлөрүүлэх нөөц боломжийг тооцоогүй байна.
- Авто машины зам ашигласны төлбөрийн хэмжээг тогтоосон боловч авто замын зурвас газарт үйлчилгээ эрхэлсний төлбөрийг тогтоогоогүй байна.
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 30.0-40.0 хувиар, төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг 30.0 хувиар нэмэгдүүлсэн болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг төрд ажилласан жилээр тооцсоноор цалин, НДШ-ийн зардлыг 2,115.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн өргөн мэдүүлсэн байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөөгүй байна.
- Аймгийн ОНХС болон ОНХО-аар төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөдөг зөрчил давтагдсаар байна.
- Тухайн байгууллагын урсгал зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой, хэт жижиглэсэн төсөл, арга хэмжээ болон улсын төсөвт байгууллагуудын зардлыг ОНХО-ын төсөвт тусгасан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Б.НАРАНТУЯА-Д:

- Хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн төлөвлөгөөнд зураг төсөв, үнэ өртгийн тооцоо судалгаа, иргэдийн саналаар баталгаажсан зэрэг төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг батлах.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Н.ЛХАГВАДОРЖ-Д:


- Аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламжийн 2,400.0 сая төгрөгийн орлогыг гэрээ хэлцэл болон бусад дэмжих баримтаар баталгаажуулсны үндсэн дээр төлөвлөх, уг орлогын эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын бус ОНХС-ийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр өргөн мэдүүлэх.
- Сумдын төсвийн үндсэн тэнцлийн ашгаас аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тооцсон 6,303.5 сая төгрөгийн орлого нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасан нөхцөл, боломж, хувь хэмжээг хангаж буй эсэхийг дахин тооцоолж, хуулийг хэрэгжүүлэн ажиллах.
- Өмнөх онуудын татварын өрийн тодорхой хэсгийг барагдуулснаар орлого төвлөрүүлэх нөөц боломжийг тооцох.
- Төсвийн зарлагын төлөвлөгөөг холбогдох хууль эрхийн актуудад нийцүүлэн үр ашиг, үр нөлөө, арвилан хэмнэлттэй байхаар өргөн мэдүүлэх.
- Тухайн байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлэх боломжтой хэт жижиглэсэн, тоног төхөөрөмж худалдан авах зардлууд болон улсын төсөвт байгууллагуудын зардлыг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй байх замаар хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ